

## **ТАЙЛАНГИЙН АГУУЛГА**

- 1. БОДЛОГО ЗОРИЛТЫГ ХАНГАХ ТАЛААР**
- 2. ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**
- 3. ЭД ХӨРӨНГӨ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**
- 4. ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА**
- 5. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**
- 6. АРХИВ, АЛБАН БИЧИГ ХӨТЛӨЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**
- 7. СУРГАЛТ, СЕМИНАР БОЛОВСОН ХҮЧНИЙГ БЭХЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР**
- 8. ХЭЛТСЭЭС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БУСАД АЖЛУУД**
- 9. ДҮГНЭЛТ**

## 1. БОДЛОГО ЗОРИЛТЫГ ХАНГАХ ТАЛААР

2025 оны тайлант хугацаанд Шинэ сэргэлтийн бодлого, Алсын хараа 2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, Улсын бүртгэлийн байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө, Улсын бүртгэлийн ерөнхий газрын “Төрийн хүртээмж нийгмийн баталгааг хэрэгжүүлэх” нэрлэсэн жилийн үйл ажиллагааны хэрэгжилтийг ханган ажиллалаа.

2025 онд УБЕГ-ын даргын 12 тушаал, 13 чиглэл, 14 зөвлөмжийн хэрэгжилтийг ханган, тайланг хугацаанд нь хүргүүлэн, УБЕГ-с зохион байгуулсан 35 удаагийн цахим болон танхимын сургалтанд хэлтсийн албан хаагчдыг бүрэн хамруулж ажилласан.

Хэлтсийн 36 албан хаагчийн 2024 оны ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд цахимаар хүлээн авч баталгаажуулах, цаасан хэлбэрээр хүлээн авах, бүртгэх хадгалах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, шинээр томилогдсон 7 нийт 40 албан хаагчийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргуулан баталгааны маягтыг УБЕГ-т хүргүүлэн, нууцын баталгааг гаргуулан ажилласан. Мөн хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний 5 дугаар зорилтын хүрээнд “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг 100 хувь ханган ажиллаж байна.

Хөвсгөл аймгийн хэмжээнд байгаа улсын бүртгэлийн 3 киоск машины 2 нь Мөрөн суманд хэлтсийн байранд болон, Рэнчинлхүмбэ суманд байршиж байгаа бөгөөд тайлант хугацаанд нийт 6211 иргэн улсын бүртгэлийн киоск машинаас 12 төрлийн лавлагаа авсан байна.

Хөвсгөл аймгийн 23 сум, 1 тосгонд хүрч үйлчлэх хүчин чадал бүхий автомашиныг шийдвэрлүүлэх хүсэлтийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Давааням, Хууль зүй дотоод хэргийн сайд Л.Мөнхбаатар нарт хүргүүлэн ажиллаж байна.

Хууль зүй дотоод хэргийн салбарын орон нутгийн албан хаагчдын эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлсийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор хэрэгжүүлсэн “Хамгийн чухал нь-эрүүл мэнд, хамгийн чухал нь алба хаагчид” зорилтот арга хэмжээ тус аймагт 2025 оны 01 дүгээр сарын 08-12-ны өдрийн хооронд зохион байгуулагдаж тус хэлтсийн 21 албан хаагч, гэр бүлийн 15 гишүүн нийт 36 хүнийг хамруулан ажилласан.

Улсын бүртгэлийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, алслагдсан сум, багийн иргэдэд Улсын бүртгэлийн үйлчилгээг ойртуулах ажлын хүрээнд “ГАРТ ОЙР-ГЭРТ ОЙР-ГАДААД ПАСПОРТ” арга хэмжээг 2024 онд хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2024 онд 8 сум үндэсний энгийн гадаад паспортын бүртгэл хөтөлж байсан бол 2025 онд Жаргалант, Шинэ-Идэр, Ханх, Алаг-Эрдэнэ сумд 21 800 000 /хорин нэгэн сая найман зуун мянга/-н төгрөг шийдвэрлүүлж сумдад 1066 бүртгэл хөтлөгдсөн байна.

Мөн 2025.01.17-ны өдөр Баянзүрх, Жаргалант, Их-Уул, Рашаант, Цагааннуур, Цагаан-Үүр, Цэцэрлэг, Чандмань-Өндөр, Эрдэнэбулган, Мөрөн сумын Засаг даргын тамгын газарт улсын бүртгэлийн зөөврийн 4G төхөөрөмжийн төсөв шийдвэрлүүлэх хүсэлтийг хүргүүлж 2025.04.12-30-ны өдрийн хооронд гэрээ байгуулан 4G төхөөрөмжийн 7 200 000 төгрөгийн худалдан авалт хийгдсэнээр 10 сумын 57 багийн 71400 иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээ хүрч үйлчлэх боломж бүрдэж зорилтод бүлгийн 121 иргэнд бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн.

Монгол улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн “Ажил амралтын цагийн зохицуулалтын тухай” 109 дүгээр тогтоолын дагуу 2025.04.12, 2025.05.10, 2025.06.07-ны өдрийн Бямба гарагт ажиллах хуваарийг батлан иргэдэд улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэн ажилласан. Мөн Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын 2025 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн А/127 тушаалын дагуу 07 сарын 01-нээс 07 сарын 29-ны хүртэл өглөө 7-12, 13-17 цагийн хооронд ажилласан.

Тус хэлтэс нь Улсын бүртгэлээс үйлчилгээ авч буй иргэдийг шаардлагатай мэдээллээр хангах, чиглүүлэх, үйлчилгээний заалны зохион байгуулалтыг хариуцан ажиллах “Угтах үйлчилгээний ажилтан”-г 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс ажиллуулж эхэлсэн бөгөөд иргэд сэтгэл ханамж өндөр байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын баталсан 2025.08.29-ний өдрийн 1/231 удирдамжийн дагуу тус хэлтсийн дотоод сүлжээнд ашиглагддаг 39 компьютерт үзлэг, оношилгоо, засвар үйлчилгээ, Domain Control системд холбох ажлыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Мэдээлэл технологийн газраас 2025.09.16-19-ний өдрийн хооронд зохион байгуулсан.

Монгол улсын Засгийн газрын 86 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 01 албан даалгаврын хэрэгжилтийг хангаж, хэлтсийн гадна талбайн камерыг “Теле камерын хяналтын дэд төв”-тэй холбож, бичлэг хадгалах лицензийн зардлыг хэлтсийн төсвөөс шийдвэрлэн ажиллалаа.

“Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ийн хүрээнд иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн самбар, бүрдүүлбэр материалын хавтсыг шинэчилж монгол, кирилл хосолсон бичгээр үйлчилгээний зааланд байршуулсан.

Архив, бичиг хэргийн эрхлэгчийн тоног төхөөрөмжийг (1.994,250) үнэ бүхий Intel @Core TM I7-14700 2.10GHz8 16.0 GB Ram8 Dell Optiplex 7020 өргөтгөлтэй үйлдийн системтэй компьютерээр бүрэн шинэчилж архив, албан хэрэг хөтлөлтийн талаар баримтлах чиглэлийг хэрэгжүүлэхэд шаардагдах “Болорсофт” ХХК-ийн Кимо хөрвүүлэгч монгол бичгийн программын гэрээг 1 жилээр 89000 мянган төгрөгөөр худалдан авч тушаал, албан бичгийн хосолсон бичвэрээр үйлдэж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд тэгш оролцох эрхийг хангах ажлын хүрээнд Харааны бэрхшээлтэй иргэнд зориулагдсан “ТАРТЕЛИН” замтай боллоо. /Замын төсөв бүхий 600.000 төгрөгийг хэлтсийн урсгал зардлаас шийдвэрлэсэн/. Мөн Иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн бүрдүүлбэр материалыг брайл үсгээр бэлтгэн

“БРАЙЛ ҮСГИЙН ГАРЫН АВЛАГА” үйлчилгээний зааланд байршуулснаар нэг иргэн брайл үсгийн гарын авлага ашиглан иргэний улсын бүртгэлийн үйлчилгээ авсан.

Хэлтсийн хэмжээнд 2025 оныг “Архивын жил” болгон төлөвлөгөө, батлагдсаны дагуу хэрэгжилтийг үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд хэлтсийн архивын өрөөнд 280 000 төгрөгийн үнэ бүхий 3 ширхэг галын хор, 2 ширхэг хүрз, 2 ширхэг лоом, 1 ширхэг сүх зэрэг багаж хэрэгслийг авч гамшиг, эрсдлээс урьдчилан сэргийлэн ажиллаж байна. Тус хэлтсийн байр нь улсын онцгой объектод хамаардаг тул хэлтсийн 2 давхрын аваарын шатанд стандарт төмөр хаалга хийж, цоожлон хэлтсийн байрны аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Улсын бүртгэлийн ерөнхий газраас архивын угсармал төмөр 8 тавиур шийдвэрлүүлж хуулийн этгээд, байгууллагын архив, складад байршуулсан.

Хөвсгөл аймгийн Мөрөн сумаас зохион байгуулж буй “Мөрөн хотдоо өнгө нэмье” аяны хүрээнд хэлтсийн гадна талын хаягийг хос бичгээр бичин байршуулж, камерын хяналтын системд холбогдсон. Мөн хэлтсийн гадна талбайн мод, бут, ногоон байгууламжийг нэмэгдүүлэн 10 ширхэг голт бор тарьж, цэцгийн үрийг суулган, хэлтсийн гадна талбайг цэвэр, аюулгүй орчин болгон ажиллалаа.

#### **Нэгжийн ил тод байдлыг хангах ажлын хүрээнд:**

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2025 оны 1/8361 албан даалгавар үндэслэн “Классик сити” ХХК-д 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хэлтсийн холбогдох материалыг хүргүүлж 2025 оны 08 дугаар сарын 10-12 өдрүүдэд дохиолол хяналтын системийн тоног төхөөрөмж шинээр угсарч суурилуулан ажиллагаанд оруулсан. Хэлтсийн 7 албан хаагчдад дохиолол хамгаалалтын системд нэвтрэх бүртгэлийг нээж үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Дохиолол хамгаалалтын системд холбогдсон тухай мэдээллийг албажуулан аймгийн цагдаагийн газар, тагнуулийн хэлтэст 2025 оны 08 дугаар сарын 13 өдрийн 30/1106 албан бичгээр хүргүүлсэн.

2025 оны тайлант хугацаанд хэлтсийн 14 хурал, даргын зөвлөлийн 11 хурал, сумын улсын бүртгэгч нарын 11 цахим хурал тус тус болсон бөгөөд хурлын тэмдэглэлийг хөтлөн албажуулж, өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Тус хэлтсийн [marage.gov.mn](http://marage.gov.mn), улсын бүртгэл пэйж цахим хуудсанд байршуулбал зохих нээлттэй мэдээллийг байршуулах хугацаа, давтамжийн дагуу байршуулж хэвшсэн бөгөөд улирал, хагас жил, сар бүр, тухай бүр байршуулах тайлан, сар бүрийн тоон мэдээ, цаг үеийн мэдээ мэдээллийг өдөр бүр байршуулан ажиллаж байна. Цахим хуудасны “Танилцуулга” цэсэнд байгаа нэгжийн бүтэц, албан тушаалтан, утасны мэдээллийг шинэчлэн, иргэдэд илүү ойлгомжтой байдлаар бүтцийн мэдээллийг шинэчлэсэн.

Монгол улсын Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 49 дүгээр “2023-2024 оныг авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай” тогтоолын дагуу авлигатай тэмцэх 5 үйл ажиллагааны 1 болох Шил ажиллагаа нь ил тод нээлттэй байдлыг ханган ажиллаж байна. Уг ажлын хүрээнд [shilen.gov.mn](http://shilen.gov.mn) сайтад 5

чиглэлийн 42 нээлттэй мэдээллийг байршуулан I улиралд 81.98%, II улиралд 100% III улиралд 100% дүгнэгдэж улсын хэмжээнд 2 дугаарт эрэмбэлэгдсэн байна.

Иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэх, иргэдийг мэдээ мэдээллээр хангах, иргэн бүрт хүрч үйлчлэх зорилгоор үйлчилгээний зааланд байрлах иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн “Хөтөч” хавтсыг тус бүр шинэчлэн, иргэдэд илүү хялбар байдлаар хэвлэн байршууллаа.

Хууль зүй дотоод хэргийн яамнаас хэрэгжүүлж буй төсвийн гүйцэтгэлийн OPENGOV программд сар бүрийн төсвийн гүйцэтгэл болон 2026 оны төсвийн төслийг шивж оруулж хэвшсэн.

Тайлант хугацаанд Хөвсгөл аймгийн хэмжээнд Улаан-Уул сумын улсын бүртгэгчийн ажлын байрны сул орон тоо Улсын бүртгэлийн ерөнхий газрын Төрийн албаны салбар зөвлөлийн захиалгаар зарлагдаж тусгай шалгалтад тэнцсэн Б.Содномцэрэн Улсын бүртгэгчийн албан тушаалд томилогдсон.

#### **Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиглэлээр:**

Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн 2025.01.16-ны өдрийн 2/899 албан бичгийн дагуу Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалтад холбогдох хууль тогтоомжид заасан шалгуур үзүүлэлт хангасан, хувийн зардлаар суралцах хүсэлтэй 3 албан хаагчийн холбогдох мэдээллийг ХАСХ-т хүргүүлсэн.

Албан хаагч, ажилтнуудыг шагнал, урамшуулалд нэр дэвшүүлэх ажлыг зохион байгуулж Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025.05.07-ны өдрийн 2/6317 албан бичгийн дагуу Төрийн дээд, Засгийн газрын болон төрийн албаны, салбар, байгууллагын шагналд шагнуулахаар нэр дэвших шаарлага хангасан 7 албан хаагчийн материалыг холбогдох журмын дагуу бүрдүүлж хүргүүлсэн.

Хэлтсийн дэргэдэх “Эцэг эхийн зөвлөл”-ийн 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу “Хүүхдийн баяр”-ыг тохиолдуулан 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдөр байгууллагын бүх албан хаагчдын хүүхдүүдийн дунд гар зургийн уралдаан зохион байгуулж, бэлэг дурсгалын зүйл гардуулсан. Мөн хэлтсийн албан хаагчдын хүүхдүүдийг хүлээн авч баярын үйл ажиллагаа зохион байгуулж, зардлыг албан хаагчдын хуримтлалын мөнгөнөөс шийдвэрлэсэн.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 2/1988 албан бичгийн дагуу хэлтсийн хэмжээнд шинээр болон ахиулан зэрэг дэв олгуулахаар 13 албан хаагчийн судалгааг УБЕГ-т хүргүүлсэн.

Хэлтсийн хамт олон хүүхдийн нийгмийн хамгааллыг дэмжих зорилгоор 1 бүтэн өнчин хүүхдийг асран хамгаалахад 11 дэх жилдээ дэмжлэг үзүүлэн хадгаламжийн дансанд жилийн 400 000 төгрөгийн хуримтлал үүсгэн байршуулж нийт 4 800 000 төгрөгийг ирээдүйд нь хувь нэмэр оруулж байна.

Тосонцэнгэл, Цагаан-Уул, Ханх, Чандмань-Өндөр сумын улсын бүртгэгч нар тухайн сумын Засаг даргын тамгын газрын нэгдсэн зохион байгуулалттайгаар Улаанбаатар хот дахь Төрийн тусгай албан хаагчдын эмнэлэг, Орхон аймгийн Эрдэнэт Медипас эмнэлэгүүдэд хийгдэж буй эрүүл мэндийн бүтэн биеийн

оношлогоо, шинжилгээнд хамрагдахад 5 хүртэл хоногийн цалинтай чөлөө олгож мөн иргэний улсын бүртгэгч Б.Батжаргал, С.Дэлгэрмөрөн, Цагаан-Уул сумын улсын бүртгэгч нар аймгийн нэгдсэн эмнэлэг болон Орхон аймгийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх, хагалгаанд орох үед цалинтай чөлөөг чөлөөний хуудсаар олгож үүрэгт ажлыг нь бусад албан хаагчаар давхар гүйцэтгүүлэх байдлаар зохицуулалт хийж ажилласан байна.

“Монгол цэргийн баярын өдөр”-ийг тохиолдуулан төрийн цэргийн болон үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагын албан хаагчдын дунд зохион байгуулагдсан спортын 6 төрөлтийн тэмцээн 2025 оны 03 дугаар сарын 11-15-ны өдрүүдэд оролцож шатрын эрэгтэй төрөлд Түнэл сумын улсын бүртгэгч Н.Дандар “Тэргүүн байр”, шатрын эмэгтэй төрөлд Цагаан-Уул сумын улсын бүртгэгч Д.Ичинхорлоо “Гутгаар” байр тус тус эзэлсэн.

Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилгоор Хэлтсийн дарга аймгийн засаг даргад хүсэлт гаргасны дагуу 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн А/227 дугаар захирамжаар 10.000.000 төгрөг “Хууль хяналт, цэрэгжсэн байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн зардал”-аас шийдвэрлүүлж 2025 оны 08 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд Улаанбаатар хотын “And medical” эмнэлэгт 17 албан хаагч үзлэг оношилгоонд хамрагдаж Төв аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаатай танилцаж ажил мэргэжлийн туршлагаа солилцон хамтран ажилласан.

Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн газраас зохион байгуулсан “Энэ жилдээ Эрүүл жиндээ-2 арга хэмжээний хүрээнд 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр Хөвсгөл аймгийн биеийн тамирын спортын газрын Нийтийн биеийн тамирын арга зүйч Б.Батаа, Б.Пагамдулам нарыг урьж хэлтсийн 19 албан хаагчийн биеийн тэнцвэр, хурд хүчний сорил авч, биеийн жингийн индекс тооцуулж, биед гарсан өөрчлөлтийн талаарх зөвлөгөө мэдээлэл авав.

Хөвсгөл аймгийн хэлтсийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн Б/01 “Ээлжийн амралт олгох тухай” тоот тушаалаар 43 албан хаагчийн ээлжийн амралтын хуваарийг батлан бүх албан хаагчид хуваарийн дагуу ээлжийн амралтаа биеэр эдэлсэн байна.

Тайлант хугацаанд хэлтсийн 14 албан хаагчдад Хөдөлмөрийн дотоод журмын дагуу хувийн чөлөө хүссэн шалтгаан, нөхцлийг харгалзан үзэж 5 өдөр хүртэл хугацааны цалинтай болон цалингүй чөлөөг олгон ажилласан.

Батлагдсан томилолтын зардлаас 540 000 төгрөгийг Улаан-Уул сум, Ханх сумын улсын бүртгэгч нарын ажил хүлээлцэх ажлын хэсгийн томилолтын зардалд зарцуулсан.

Хөвсгөл аймгийн Засаг даргын баталсан “Амьдрах орчноо сайжруулж, Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих” жил болгон зарласантай холбогдуулан хэлтсийн өрх толгойлсон болон алдарт эхийн одонтой албан хаагчдын судалгааг ЗДТГ-т хүргүүлэн 4\*6 хэмжээтэй хүлэмжийг 4 албан хаагчид гардуулан өгсөн.

Олон улсын ахмадын баярын өдрийг тохиолдуулан хэлтсээс өндөр насны тэтгэвэрт гарсан 10 ахмад настанд урилга хүргүүлж 10 сарын 01-ны өдөр хэлтсийн даргын өрөөнд хүлээн авч хүндэтгэл үзүүлэн гурван үеийн туршлага солилцох ярилцлагын хийж, 85 жилийн түүхэн ном бүтээх санал, даалууны тэмцээн, эмчийн үзлэг зэргийг зохион байгуулж нэг өдрийн хүндэтгэл, дурсамж дүүрэн өнгөрүүлж ахмадуудаа хүндэтгэн гарын бэлэг гардууллаа.

## 2. ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасаг нь тайлант хугацаанд Монгол улсын үндсэн хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Гэр бүлийн тухай хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Иргэний улсын бүртгэл хөтлөх журам, Монгол улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам болон холбогдон гарсан бусад дүрэм журмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн Иргэний улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхолыг хүндэтгэх, иргэний хувийн нууцыг чандлан хамгаалах зарчмыг баримтлан ажиллалаа. Бүртгэлийн байгууллагын эрхэм зорилгын хүрээнд аймгийн нийт сумдад анхан шатны бүртгэлийн үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

### **Нэг. Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр:**

2025 оны тайлант хугацаанд төрсний бүртгэл **1598** үүнээс эрэгтэй 823, эмэгтэй 775, гэрлэсний бүртгэл **317**, гэрлэлт дуусгавар болсны бүртгэл **101**, үрчилсний бүртгэл **37**, эцэг /эх/ тогтоосны бүртгэл **79**, ургийн овог, эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэл **93**, нас барсны бүртгэл **680** бүртгэл тус тус хийгдэж цахим мэдээллийн санд баталгаажсан байна.

Иргэний улсын бүртгэлийн 8 төрлийн бүртгэлд алдаатай, буруу, дутуу бүртгэгдсэнээс үүдсэн зөрчилтэй 224 иргэний бүртгэлийн ХААТР, ИУБ маягтыг архиваас татан авч цахимжуулан, Хяналтын улсын байцаагчийн 4865, 6839 дугаартай нэгдсэн дүгнэлтээр бүртгэлийн зөрчлийг арилгаж, нэмэлт өөрчлөлтийн бүртгэл хөтлөн ажилласан. Үүнээс төрсний бүртгэлийн нэмэлт өөрчлөлт 62, овог, эцэг, эхийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэлийн нэмэлт өөрчлөлт 103, эцэг, эх тогтоосны нэмэлт өөрчлөлт 5, үндсэн сангийн өөрчлөлтөөр галиг зассан 15, нас барсны бүртгэлийн нэмэлт өөрчлөлт 2, үрчилсний бүртгэлийн нэмэлт өөрчлөлт 2, гэрлэсний бүртгэлийн төлөв зассан 14, гэрлэсний бүртгэлийн нөхөн бүртгэл 21 тус тус бүртгэсэн байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газар болон иргэний улсын бүртгэлийн газраас ирүүлсэн зөвлөмж чиглэлийг тухайн цаг бүрт сумдын улсын бүртгэгч нарт мэдээлэл хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

### **Хоёр. Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийн чиглэлээр:**

Бусад аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн **628** бүртгэл үүнээс насанд хүрсэн 351, хүүхэд /16-аас доош насны/ 277, сум хооронд шилжин ирсэн **1092** бүртгэл үүнээс насанд хүрсэн 578, хүүхэд /16-аас доош насны/ 514, баг хооронд шилжин ирсэн **1526** бүртгэл үүнээс насанд хүрсэн 750 хүүхэд /16-аас доош насны/ 776 иргэний бүртгэл хийгдэж цахим мэдээллийн санд баталгаажсан байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасны дагуу Иргэний улсын бүртгэлийн газраас ирүүлсэн зөвлөмжийн дагуу нөхөн сонгууль зохион байгуулагдах Алаг-Эрдэнэ, Ханх, Цагаан-Үүр сумдын иргэний шилжилт хөдөлгөөний иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлд тогтмол хяналт тавин ажиллаж Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн А/71 тушаалын дагуу иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг түр зогсоон, бүртгэлд хяналт тавин ажилласан.

**Гурав. Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл буюу Иргэний үнэмлэх олголт:**

Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл буюу цахим үнэмлэх олголтын 5792 бүртгэл үүнээс шинэ 2130, хаяж үрэгдүүлсэн 1428, гадаад улсад бүртгүүлсэн 1, хорин таван насны сунгалт хийлгэсэн 966, дөчин таван насны сунгалт 1264 бүртгэл хийгдэж, 5792 иргэний цахим үнэмлэх хэвлэгдэн, иргэдэд олгогдсон байна. 4363 иргэний цахим үнэмлэхний зураг засаж иргэний үнэмлэх хэвлүүлсэн.

Шинээр иргэний үнэмлэх авах насанд хүрсэн мөн 25 ба 45 насны сунгалт хийлгэх насанд хүрсэн боловч хүндэтгэн үзэх шалтгааны улмаас өөрийн биеэр ирж биеийн давхцахгүй өгөгдөлийн бүртгэлд хамрагдах боломжгүй иргэдийг тухайн байгаа газарт нь очиж ИШБүртгэлд хамруулан бичиг баримтжуулах ажлыг зохион байгуулан ажиллаж 5 иргэнд хүрч үйлчилсэн байна.

**Дөрөв. Гадаадад зорчих эрхийн бүртгэлийн хүрээнд:**

Үндэсний энгийн гадаад паспорт захиалах ажлын хүрээнд нийт 5054 иргэний гадаад паспортын захиалга авч, 4720 хүсэлтэд Е дугаар бичин 5028 хуудас сканнердаж мэдээллийн санд цахимжуулсан байна.

Хил орчмын нутаг дэвсгэрт хялбарчилсан журмаар зорчих үнэмлэх олгох буюу ОХУ-ын хавсралтын бүртгэл 655 бүртгэгдсэн байна.

**Тав. Иргэний баримтын архивын ажлын хүрээнд:**

Тайлант хугацаанд тус хэлтсийн иргэний баримтын архивын лавлагаа, улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн "Нээлттэй" мэдээллийг иргэдэд 9912, хууль хяналтын байгууллага болон бусад байгууллагад 987, албан хэрэгцээнд 1708 лавлагааг олгосон.

Иргэний баримтын архивт иргэний улсын бүртгэлийн 8956 ИУБ маягтуудын баяжилт хийсэн. Үүнд төрсний бүртгэл /ИУБ-11/ 1598, үрчилсний бүртгэл /ИУБ-12/ 37, ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл /ИУБ-13/ 93, эцэг тогтоосны бүртгэл /ИУБ-14/ 79, гэрлэсний бүртгэл /ИУБ-15/ 317, гэрлэлт дуусгавар болсны бүртгэл /ИУБ-16/ 101, нас барсны бүртгэл /ИУБ-18/ 680, биеийн давхцахгүй өгөгдөлийн бүртгэл /ИУБ-31/ 4363, шилжин ирсний бүртгэл /ИУБ-22/ 1679, бусад аймаг хотод бүртгэл хийлгэсэн 298 иргэдийн хувийн хэргийг иргэний баримтын архивт баяжилт хийсэн.

Иргэний улсын бүртгэл хөтлөх журмын 22.5-д заасны дагуу иргэний улсын бүртгэлд бүртгүүлэхээр хууль тогтоомжид заасны дагуу бүрдүүлсэн баримт бичгийг 24 сумын улсын бүртгэгчээс татан авч хадгаламжийн нэгж үүсгэн, 2025 оны бүртгэлийн 308 дэвтэр болон бүрдүүлбэрийг хадгалалтын стандартын шаардлагын дагуу хүлээн авч архивт хүлээн авсан.

Иргэний бүртгэлийн мэдээллийн санд тухайн иргэний болон эцэг, эхийн мэдээлэл зөрсөн болон зөрчилтэй 91 ХААТР, ИУБ маягт холбогдох бүртгэлийн дэвтрийн хуулбарыг мөн тухайн бүртгэлтэй холбоотой дэвтэр шүүж зөрчил арилгуулахаар иргэний улсын бүртгэгчид хүлээлгэн өгч, зөрчлийг арилган буцаан авч архивт байршуулсан байна.

Архивын ерөнхий газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/91 тушаал, “Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалт батлах тухай” Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн байгууллагын болон иргэний баримтын архив, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архив, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивын хадгалах хугацаа нь дууссан баримтуудыг салбарын жагсаалтаар судалгаа гарган БНШК-н хурлаар хэлэлцүүлэн, акт үйлдэн устгасан байна.

Хэлтсийн архивын үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр Аймгийн архивын тасагт хүсэлт тавьсны дагуу тус хэлтэст нэг мэргэжилтэн ажиллаж архивч нарт байгууллагын архив, төрөлжсөн архивын эх нотлох баримтын хадгалалт хамгаалалт, стандартыг хэрэгжүүлэх талаар заавар зөвлөмж өгч ажилласан.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 9/4940 албан бичгээр “Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санг цэгцлэх” чиглэлийн дагуу “Ажлын төлөвлөгөө” гарган хэлтсийн даргаар батлуулж 1456 иргэний хувийн хэргийн Б талыг цахимжуулсан байна.

Иргэний баримтын архивын хувийн хэргийн сан болон ИГБББ-ийн дэвтрүүдийг сэлбэн засаж, хувийн хэргийн санд хадгалагдах иргэдийн хувийн хэргийг тус бүр дугтуйлж, зориулалтын хайрцагт бичилт хийж тавиурт галигийн дагуу байршуулан ажиллаж байна.

**Зургаа. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын нөхөн сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд:**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу Хөвсгөл аймгийн хэмжээнд нөхөн сонгууль зохион байгуулагдах Алаг-Эрдэнэ, Ханх, Цагаан-Үүр сумын сонгуулийн хэсэг байгуулах тухай сумын ИТХ-н тогтоолыг хуулийн хугацаанд хүлээн авч цахимжуулан, улсын бүртгэлийн мэдээллийн санд хэсгийн төв, санал авах байрыг шивж оруулан тогтоолын эх хувийг Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлсэн.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын нөхөн сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөний дагуу хэсэг оноогдоогүй сонгогчид хэсэг оноох, илэрсэн зөрчил арилгах, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 6-д заасны дагуу “Түр хасав” төлөв оноосон сонгогчийн мэдээллийг шалгаж “түр хасав” төлөв сэргээх хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэн ажилласан.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт заасны дагуу иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг түр зогсоохтой холбоотойгоор Иргэний улсын бүртгэлийн газраас ирүүлсэн чиглэлийн хүрээнд иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлд тогтмол хяналт тавин ажиллаж Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн А/71 тушаалын дагуу иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг түр зогсоон, бүртгэлд хяналт тавин ажиллалаа.


Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалтыг холбогдох хууль, журмын хүрээнд нягтлан шалгаж 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр хэвлэж, нөхөн сонгууль зохион байгуулах Алаг-Эрдэнэ, Ханх, Цагаан-Үүр сумын сонгуулийн хороонд хуулийн хугацаанд хүлээлгэн өгч тухайн сумын улсын бүртгэгч нар сонгуулийг 2025 оны 6 дугаар сарын 22-ны өдөр амжилттай зохион байгуулан ажилласан.

**Долоо. Цахим гарын үсэг олгох ажлын хүрээнд:**


Аймгийн хэмжээнд тоон гарын үсэг авах 90464 иргэнээс 2024 оны жилийн эцэст 20973 иргэнд тоон гарын үсэг олгож, нийт 72461 иргэнд тоон гарын үсэг олгож, тоон гарын үсэг олгох ажил 80.09%-тай байсан бол 2025 оны тайлант хугацаанд киоскоор 685159, бүртгэгч олгосон 5648 нийт 690807 иргэнд тоон гарын үсэг олгож, нийт тоон гарын үсэг давхардсан тоогоор 771386 иргэнд олгосон байна.

Цахим гарын үсгийн тухай хууль, улсын бүртгэлийн байгууллагаас Монгол улсын 16 насанд хүрсэн иргэнд тоон гарын үсгийн гэрчилгээ олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журмын хүрээнд Хөвсгөл аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн 31 албан хаагч, Хуульчдын “Про боно” өдөрлөгөөр 36 иргэнд тоон гарын үсэг олгосон байна.


**Найм. Иргэний улсын бүртгэлийг графикаар харуулбал:**




### Иргэний шилжилт хөдөлгөөн



### Иргэний биеийн давхцахгүй өгөгдөлийн бүртгэл



### Үндэсний энгийн гадаад паспорт



### 3.ЭД ХӨРӨНГӨ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасаг нь тайлант хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журам, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журам, Хуулийн этгээдийн нэр олгох, баталгаажуулах журам, Иргэн, хуулийн этгээдийн тамга тэмдэг баталгааны тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журам болон бусад холбогдох хууль, журам, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Иргэний хууль, Нотариатын тухай хууль, Хоршооны тухай хууль, Компаний тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, Улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох тухай Монгол улсын засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 230 дугаар тогтоол, УБЕГ-аас ирүүлсэн чиглэл, журмын хүрээнд эд хөрөнгийн эрхийн бүртгэл болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэн ажиллалаа.

2025 оны тайлант хугацаанд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн нийт **12461** мэдүүлэг хүлээн авч, холбогдох бүртгэлийг хөтлөн ажилласан ба хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр **1332** материал хүлээн авч бүртгэл хөтөлсөн байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг Баянзүрх, Галт, Их-Уул, Тариалан, Хатгал, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр, Шинэ-Идэр, Рашаант, Цэцэрлэг, Эрдэнэбулган зэрэг 11 сумдын улсын бүртгэгч нарт хуулийн этгээдийн улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх эрх олгосон. Ингэснээр сумдад эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл 1827, хуулийн этгээдийн улсын бүртгэл 302 хөтлөгдсөн байна.

Тайлант хугацаанд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн 7 чиглэл, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн 6 чиглэл зөвлөмжийг улсын бүртгэгч нарт тухай бүр танилцуулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Шинээр батлагдан гарсан хууль, тогтоомж болон цаг үеийн үйл ажиллагаатай холбогдуулан Улсын бүртгэлийн ерөнхий газар, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн чиглэл, дүрэм журмуудыг уншиж судлан хэрэгжилтийг ханган холбогдох ажлуудыг зохион байгуулан ажиллалаа.

## ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:


Иргэдээс “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль”-ийн 14 дүгээр зүйлийн 14.1.7-д заасан шалтгаанаар хувийн хэрэг хаалгахаар ирүүлсэн хүсэлт холбогдох баримт бичиг, мэдүүлгийг үндэслэн үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 51, газар өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 15 хувийн хэрэг бүртгэлийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны 8 дугаар сарын А/1614 дугаар тушаалыг үндэслэн хаасан байна. Мөн иргэн хуулийн этгээдээс үрэгдүүлсэн гэрчилгээг дахин авах тухай өргөдөл хүсэлт, нотлох баримтыг үндэслэн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр хүчингүйд тооцуулж үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 43, газар өмчлөх эрхийн 32 гэрчилгээг дахин олгож ажиллалаа.

Тайлант хугацаанд бүртгэсэн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг төрөл тус бүрээр ангилан авч үзвэл:


### 1.1 Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг анх удаа бүртгэх:


Тайлант хугацаанд газар өмчлөх эрх болон газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн анхны бүртгэлийн үйчилгээг иргэдэд хуулийн хугацаанд түргэн шуурхай үзүүлж газар өмчлөх эрхийн бүртгэл нийт **258**, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн анхны бүртгэл **901** бүртгэж, нийт **1159** хувийн хэрэг шинээр үүсгэн архивт байрлуулсан байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хүлээн авсан мэдүүлгийн тоон үзүүлэлтийг сүүлийн 3 жилээр харьцуулбал:



Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийг анх удаа бүртгэх бүртгэлийн тоон үзүүлэлтийг сүүлийн 3 жилээр харьцуулбал:






### 1.2. Барьцааны бүртгэл /ипотек/:

Тайлант хугацаанд үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн барьцааны бүртгэлийн **5777** мэдүүлэг хүлээн авч бүртгэсэн ба үүнээс барьцаалбартай барьцааны гэрээ **2013**, барьцаалбаргүй барьцааны гэрээ **1140**, барьцааны гэрээнд өөрчлөлт оруулах **51**, барьцааны гэрээ дуусгавар болгох **2573** тус тус хүлээн авч бүртгэсэн.

Мөн газар өмчлөх эрхийн барьцааны бүртгэлийн **3163** мэдүүлэг хүлээн авсан ба үүнээс барьцаалбаргүй барьцааны гэрээ **1672**, барьцааны гэрээнд өөрчлөлт оруулах **20**, барьцааны гэрээ дуусгавар болгох **1471**-г тус тус хүлээн авч бүртгэсэн байна.



**1.3. Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх болон түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн шилжилтийг бүртгэх:**




Тайлант хугацаанд үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрээний бүртгэл **937**, газар өмчлөх эрхийн гэрээний бүртгэл **664** нийт **1601** мэдүүлэг хүлээн авч бүртгэл хөтөлсөн байна. Үүнээс бэлэглэлийн гэрээгээр **155**, ХХАГ-ээр **1051**, өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөгдөх **229**, хамтран өмчлөгч өөрчлөгдөх бүртгэлээр **144**, өмчлөгчийн үүсгэн байгуулсан ХЭ-ээс иргэнд, иргэн үүсгэн байгуулсан ХЭ-ийн өмчлөлд өмчлөх эрх шилжих **9**, арилжааны гэрээгээр **9**, шүүхийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдөх **4** бүртгэл тус тус бүртгэсэн байна.




#### **1.4. Эрхийн улсын бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулах:**

Тайлант хугацаанд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн нэмэлт өөрчлөлт оруулах **661** мэдүүлэг хүлээн авч холбогдох өөрчлөлтийг бүртгэсэн байна. Үүнээс үрэгдүүлсэн гэрчилгээ шинээр олгох **75**, гэмтээсэн гэрчилгээ шинээр олгох **5**, эд хөрөнгийн хэмжээ өөрчлөгдөх **252**, эд хөрөнгийн зориулалт өөрчлөгдөх **18**, эд хөрөнгийн хаяг өөрчлөгдөх **299**, газрын нэгж талбарын дугаар өөрчлөгдөх **4**, өмчлөгчийн овог, нэр, регистр өөрчлөгдөх **8** бүртгэл тус тус бүртгэж, холбогдох материалыг архивт хүлээлгэн өгч ажиллалаа.



#### **1.5. Лавлагаа хуулбар олголт:**

Тайлант хугацаанд газар өмчлөх эрх болон газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн нийт **2243** лавлагаа, **3** хуулбар олгосон байна.



## **1.6. Бусад бүртгэл:**

2025 оны тайлант хугацаанд урьчилсан тэмдэглэл хийх бүртгэл 8, урьчилсан тэмдэглэл хүчингүй болгох бүртгэл 20, түрээсийн гэрээ 8, бусад гэрээнд өөрчлөлт оруулах бүртгэл 1-г тус тус бүртгэсэн байна. Мөн Монголын Ипотекийн корпораци ОССК /МИК/-аас цахимаар илгээсэн барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийн 22 мэдүүлэг хүлээн авч 22 барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийг бүртгэсэн байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 5/13341 дугаартай “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийн дагуу 10 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн нотариатчаас улсын бүртгэлийн үйлчилгээг зуучлах, мэдүүлэг гаргагчийн улсын бүртгэлийн байгууллагад гаргасан мэдүүлэг, холбогдох баримт бичгийг хуулийн шаардлага хангуулан мэдүүлэг гаргагчийн хүсэлтээр тус тус дундын мэдээллийн сангаар дамжуулан улсын бүртгэлийн мэдээллийн санд цахимаар илгээж эхэлсэн бөгөөд аймгийн хэмжээнд онлайн мэдүүлэг хүлээн авах цэсээр дамжуулан нотариат зуучлалаас 2 үл хөдлөх эд хөрөнгө шилжүүлэх хүсэлт ирсэнээс 1 үл хөдлөх шилжүүлэх гэрээг татгалзаж, 1 үл хөдлөх эд хөрөнгө шилжүүлэх хүсэлтийн дагуу бүртгэлийг хөтөлсөн.

## **ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:**


### **2.1. Хуулийн этгээд шинээр үүсгэн байгуулах бүртгэл:**

2025 оны тайлант хугацаанд шинээр үүсгэн байгуулах хуулийн этгээдийн **751** материалыг хүлээн авч улсын бүртгэлд бүртгэн, хувийн хэрэг нээн архивт хүлээлгэн өгч ажиллалаа. Шинээр хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалтын **1115** хүсэлт шийдвэрлэсэн байна


Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийг төрлөөр нь ангилбал:

- Хязгаарлагдмал хариуцлагатай компани -**235**,
- Хоршоо -**462**,
- Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар - 1
- Төрийн бус байгууллага /НҮТББ/ -**24**
- Төрийн бус байгууллага /ГҮТББ/ -**13**
- Сан-**3**
- Үйлдвэрчний эвлэлийн хороо- **11**
- Төрийн байгууллага албан газар - **2**-ыг газрыг тус тус бүртгэж хувийн хэрэг үүсгэж цахимжуулан архивт хүлээлгэн өгсөн байна.


Хуулийн этгээд шинээр үүсгэн байгуулах бүртгэлийн тоон үзүүлэлтийг сүүлийн 3 жилээр харьцуулбал:



Шинээр үүсгэн байгуулсан Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн бүртгэлийн тоон үзүүлэлтийг сүүлийн 3 жилээр харьцуулбал:



Шинээр үүсгэн байгуулсан Хоршооны бүртгэлийн тоон үзүүлэлтийг сүүлийн 3 жилээр харьцуулбал:



Мөн **e.business.mn**-ээр нийт **2546** нэрийн баталгаажилтын хүсэлт, цахим гэрчилгээ авах хүсэлт **18** хязгаарлагдмал хариуцлагатай компанийн бүртгэл хийлгэх болон мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн бүртгэл 7 хүсэлтийг шийдвэрлэсэн.



## 2.2 Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн бүртгэл:


Тайлант хугацаанд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн бүртгэл **527** хүлээн авч холбогдох бүртгэлийг хөтлөн, хувийн хэрэгт баяжилт хийсэн байна. Үүнээс:

➤ Хуулийн этгээдийн бүртгэлийн гэрчилгээгээ гээгдүүлсэн буюу гэмтээсэн бусад шалтгаанаар **53**,

➤ Хуулийн этгээдийн эрх шилжүүлэх болон худалдах, худалдан авах гэрэ, бэлэглэх гэрээ, өв залгамжлагчаар үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч өөрчлөгдсөн, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл дүрмийн сан, гишүүн нэмэх хасах бусад шалтгаанаар бүртгэлийн мэдээлэлдээ өөрчлөлт оруулсан **453**

➤ Татан буугдсан **11** хуулийн этгээдийн холбогдох материалыг хүлээн авч бүртгэн хувийн хэрэгт баяжилт хийн цахимжуулан архивт хуулийн хугацаанд хүлээлгэн өгсөн.






**2.3 Хуулийн этгээдийн лавлагаа, хуулбар:**

Тайлант хугацаанд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр **125** лавлагаа, **45** хуулбар олгосон байна.



## **2.4 Иргэн хуулийн этгээдийн тамга, тэмдэг баталгааны тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих:**

Иргэн хуулийн этгээдийн тамга, тэмдэг баталгааны тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журмын дагуу **794** хуулийн этгээдэд тэмдэг, баталгааны тэмдгийн хяналтын дугаарыг олгож 2025 оны тайлант хугацаанд татан буугдсан, хэлбэр ашиглалтын шаардлага хангахгүй болон бусад шалтгаанаар хураагдсан **43** ширхэг хуулийн этгээдийн тамга тэмдэг, баталгааны тэмдгийг хадгалалт хамгаалалтын шаардлага хангасан сейф шүүгээнд хадгалж хуулийн хугацаанд нь устгах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.



## **Архивын үйл ажиллагааны талаар**

Архивын баримтын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдалд байнгын хяналт тавин ажиллаж, 2025 оны архивын үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлтсийн даргаар батлуулан, төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааны биелэлтийг ханган ажиллаж хэрэгжилтийг гаргасан.



Тайлант хугацаанд хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивт газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 20398, газар өмчлөх эрхийн 13658, нийт 34056 хувийн хадгалагдаж байна. Үүнээс 2025 оны тайлант хугацаанд шинээр 469 хувийн хэрэг нээж эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивт хүлээн авч байрлуулсан ба 5297 хувийн хэрэгт баяжилт хийсэн.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивт цахим санд бүртгэлтэй 4312, татан буугдсан 342, шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй 135, хасагдсан 89 хувийн хэрэг байршиж байна. Мөн 751 шинэ хувийн хэрэг нээж хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивт байрлуулсан ба 527 хувийн хэрэгт баяжилт, тэмдэглэгээг хийж архивт буцаан байрлуулсан.

Тайлант хугацаанд Хяналтын улсын байцаагчид эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 1098 хувийн хэрэг, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 200 хувийн хэргийг тус тус татаж шалгуулан хувийн хэргийг буцаан байрлуулсан.

2025 онд Хөвсгөл аймагт шинээр баригдаж ашиглалтанд орсон нийтийн орон сууц, авто зогсоол, үйлчилгээний зориулалттай 3 үл хөдлөх эд хөрөнгийг иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлт, нотлох баримтуудыг нягтлан шалгаж Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн систем /eprs/-д цахимжуулж, Газрын харилцаа барилга, хот байгууллатын газраас олгосон хаягийн дагуу улсын бүртгэлийн мэдээллийн санд хаяг нэмж оруулан хувийн хэрэг үүсгэн улсын бүртгэлийн “Ж” дугаар олгож архивт хүлээлгэн өгсөн байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивын хадгалах хугацаа нь дууссан баримтуудын судалгаа гаргаж ББНШК-ын хурлаар хэлэлцүүлэн устгах саналыг УБЕГ-ын НАГ-т хүргүүлэн ажиллалаа.



### **Мэдээ, тайлан, хугацаатай албан бичгийн шийдвэрлэлт**

Тайлант хугацаанд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тоон мэдээг хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгон эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газар, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт тус тус хүргүүлж ажиллалаа. Улсын бүртгэгч нар гэрчилгээ болон үнэт цаасны зарцуулалтын тайланг сар бүр гаргаж хэлтсийн ахлах нягтлан бодогчоор хянуулж тооцоо нийлэн ажиллаж байна.

Хөвсгөл аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Прокурорын газар, Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх, Хөвсгөл аймаг дахь Цагдаагийн газраас ирүүлсэн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой **202**, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн **63** албан бичгийн хариу лавлагаа мэдээллийг хугацаанд хүргүүлсэн. Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас ирүүлсэн албан бичиг тогтоол шийдвэрийн дагуу **81** эрхийн улсын бүртгэлд тусгай тэмдэглэл хийж, **43** эрхийн улсын бүртгэлийн тусгай тэмдэглэлийг хүчингүй болгосон байна. Хуулийн этгээдийн бүртгэлд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас ирүүлсэн тогтоолоор хориг тавьсан **3**, цуцалсан 3 бүртгэлийг хийж хариу хүргүүлсэн байна. Мөн МИК-АКТИВ-34,35ТЗК ХХК болон ҮЦСК ХХК-ийн хүсэлтийн дагуу 98 эрхийн улсын бүртгэлд тусгай тэмдэглэл хийж, ҮЦСК-ийн хүсэлтийн дагуу 7 эрхийн улсын бүртгэлийн тусгай тэмдэглэлийг хүчингүй болгож бүртгэсэн.

### **Тэмдэгтийн хураамж, үйлчилгээний төлбөрийн талаар**

Тайлант хугацаанд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 12461 хувийн хэрэгт үйлчилгээ орсон бөгөөд тус үйлчилгээгээр 171 730 879 /нэг зуун далан нэгэн сая долоон зуун гучин мянга найман зуун далан ес/ төгрөгийн мөнгөн орлогыг төвлөрүүлсэн ба үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхээ худалдан борлуулсны 2 хувь 532 902 582 /таван зуун гучин хоёр сая есөн зуун хоёр мянга таван зуун наян хоёр/ төгрөгийг, үл хөдлөх эд хөрөнгө анх удаа бүртгүүлсний тэмдэгтийн хураамжинд 27 782 408 /хорин долоон сая долоон зуун наян хоёр мянга дөрвөн зуун найм/ төгрөгийг тус тус татварын орлогод төвлөрүүлсэн байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр тамга, тэмдгийн хяналтын дугаар болон нэрийн баталгаажуулалт, дахин гэрчилгээ, лавлагаа, хуулбарын үйлчилгээний хураамж 20 474 000 /хорин сая дөрвөн зуун далан дөрвөн мянга/ төгрөгийн мөнгөн орлогыг үйлчилгээний орлогод төвлөрүүлсэн ба тэмдэгтийн хураамжийн 39 074 000 /зучин есөн сая далан дөрвөн мянга/ төгрөгийг татварын орлогод төвлөрүүлсэн байна.

Тус хэлтэс нь “Гэрэгэ” пос машин, “Киоск” машинаар тус тус үйлчилгээний хураамжийг авч иргэдэд төрийн үйлчилгээг чирэгдэлгүй хүргэж байна.

#### 4. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хөвсгөл аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн хяналтын улсын байцаагч нь улсын бүртгэлийн алдаа, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, улсын бүртгэлийн байгууллагын ажилтны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэнд хяналт тавин ажиллахаас гадна алдаа зөрчлийг илрүүлэх, түүнийг таслан зогсоох, арилгуулах, улсын бүртгэлийн байгууллагын ажилтаны зөрчигдсөн эрх, ажил хэргийн нэр хүндийг сэргээх, улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах зорилгоор улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийн ажиллаж байна.

##### 1. Бодлого зорилтыг хангах чиглэлээр:

Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Захиргааны ерөнхий хууль болон бусад хууль, эдгээртэй нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актад заасны дагуу улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, шалгалт хийж ажиллаж байна.

Улсын бүртгэлийн алдаа, зөрчлийг илрүүлэх, түүнийг таслан зогсоох, арилгуулах, түүнээс урьдчилан сэргийлэх, улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах зорилгоор улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хяналт шалгалтын асуудал хариуцсан нэгжийн хяналтын оператор өөрийн чиг үүрэгт хамаарах улсын бүртгэлийн мэдээллийн сан, архивын эх нотлох баримт бичигт тулгалт хийх замаар алдаа, зөрчлийг илрүүлж ажиллаж байна.

Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхэд улсын алхах бүртгэгч, улсын бүртгэгч, улсын бүртгэлийн байгууллагын бусад ажилтан холбогдох эх нотлох баримт бичиг, жагсаалтыг гаргаж өгөх, хяналт шалгалтын үйл ажиллагаанд ач холбогдол бүхий программ хангамж, техник, технологийн асуудлыг шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд тухайн бүртгэлийн талаар нэмэлт мэдээлэл, тайлбар өгөх зэргээр хамтран ажиллалаа.

Ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэгт хамаарах улсын бүртгэлийн мэдээллийн сан, архивын эх нотлох баримт бичигт тулгалт хийж, илрүүлсэн алдаа, зөрчлийн талаарх мэдээг сар бүр гарган, хяналт шалгалтын асуудал хариуцсан нэгжид хүргүүлж байна.

2025 оны хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө болон ажлын байрны тодорхойлолтонд заагдсан Улсын бүртгэл, түүнтэй холбоотой бусад үйл ажиллагаанд зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, илэрсэн зөрчлийг арилгуулах, улсын бүртгэлийн ажилтны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэнд хяналт тавих чиг үүргийн дагуу **2650** бүртгэлд хяналт тавьж ажиллалаа. Үүнээс:

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр-1130, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр-1000, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр-200, Улсын бүртгэлийн архивын чиглэлээр-320 тус тус шалгаж ажиллалаа.


Тайлант хугацаанд иргэдээс өргөдөл, санал, гомдлын мөрөөр хийсэн шалгалтаар: Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр-28, Эд хөрөнгийн улсын бүртгэлийн чиглэлээр-56, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр-7, Улсын бүртгэлийн архивын чиглэлээр-0 тус тус зөрчил үүссэн бөгөөд нийт 91 дүгнэлт гарсан байна.

Зөрчлийн хуулиар 160 иргэн, хуулийн этгээдэд торгууль оногдуулсан бөгөөд Төрийн сангийн торгууль, хүү төвлөрүүлэх дансанд 3 200 000 /гурван сая хоёр зуун мянга/ төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 1/655 дугаар үүрэг чиглэлийн дагуу мөн Улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журмын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар хяналтын улсын байцаагчийн эрх бүхий албан тушаалтнууд иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд хөтлөх үйл ажиллагаанд холбогдуулан хяналтын улсын байцаагч нар өөрийн харъяалах нэгжид бүртгэгдсэн 2025 оны 01 дүгээр сарын 01-нээс 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх бүртгэлийг шалгаж ажиллалаа.

Энэхүү шалгалтыг Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 18 дугаар зүйлд заасан хяналтын үйл ажиллагаа болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын үүрэг, чиглэлд заасан ажлыг хэрэгжүүлэх, улсын бүртгэлийг цахим хэлбэрээр хянаж, бүртгэл үнэн зөв байх зарчимд нийцүүлж ажиллалаа.

Хууль, журам, албан тушаалын тодорхойлолтод заасан улсын бүртгэлийн хууль тогтоомжийг биелүүлэх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бүртгэлийн зөрчлийг гаргахгүй байх талаар нийт бүртгэгч нарт болон албан хаагчдад үүрэг даалгавар өгч ажиллалаа.




## **2. Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр**

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр иргэдээс ирсэн өргөдөл, гомдол болон иргэний улсын бүртгэгчээс ирүүлсэн хүсэлтийн дагуу 28 дүгнэлт гаргаж Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлж зөрчил арилгуулсан байна.

Дүгнэлтийн төрлөөр авч үзвэл:

- Нэмэлт өөрчлөлтөөр-10
- Регистрийн дугаар өөрчилж, дахин, шинээр олгох-10
- Бүртгэл хүчингүй болгох-8



## **3. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр:**

Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журмын дагуу байцаагчийн хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан болон өдөр тутмын түүвэрчилсэн хяналтаар эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйл ажиллагаанд хяналтыг тавьж ажиллалаа.


Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр өдөр тутмын болон түүвэрчилсэн, төлөвлөгөөт, улсын ахлах бүртгэгчээс ирүүлсэн өргөдөл зэрэг **1000** бүртгэлд хяналт шалгалт тавьж ажиллалаа.

Хяналтын улсын байцаагчийн нийт 56 дүгнэлт гаргасан бөгөөд үүнээс:

- Эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болгох - 50
- Бүртгэлд өөрчлөлт оруулах тухай – 5
- Бүртгэл хүчингүй болгох - 1

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд эрхлэн хөтөлж байгаа эсэх, түүний хадгалалт хамгаалалт, найдвартай байдлыг ханган ажиллаж байгаа эсэхэд байнгын хяналт тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 1000 бүртгэлийг мэдээллийн санд эх нотлох баримт үнэн зөв эсэх, бичиг баримт бүрэн цахимжсаныг тулгаж шалгасан байна.



#### **4. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр:**


Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журмын дагуу байцаагчийн хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан болон өдөр тутмын түүвэрчилсэн хяналтаар **200** бүртгэлийг мэдээллийн санд эх нотлох баримт бичиг бүрэн үнэн зөв цахимжсаныг тулгаж шалгасан байна.

Хяналтын улсын байцаагчийн нийт 7 дүгнэлт гарсан бөгөөд үүнээс:

- Тамга, тэмдгийн хяналтын дугаарыг хүчингүй болгох - 4
- Бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулах - 3

Хуулийн этгээдийн архивын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд эрхлэн хөтөлж байгаа эсэх, түүний хадгалалт хамгаалалт, найдвартай байдлыг ханган ажиллаж байгаа эсэхэд байнгын хяналт тавин ажиллаж байна.

**Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр хяналт шалгалт хийсэн тоон үзүүлэлтийг сүүлийн 3 жилээр харьцуулбал:**




#### **5. Архивын чиглэлээр:**

Ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэгт хамаарах улсын бүртгэлийн мэдээллийн сан, архивын баримтын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдалд байнгын хяналт тавин ажиллаж байна.

Улсын бүртгэлийн архивын чиглэлээр 320 бүртгэлд хяналт тавьж ажиллалаа.

Архивын ерөнхий газрын даргын 2023.11.23 А/91 тоот тушаалаар “Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалт батлах тухай” Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн байгууллагын болон иргэний баримтын архив, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивын хадгалах хугацаа нь дууссан баримтуудыг салбарын жагсаалтаар судалгаа гаргаж БНШК-ын хурлаар хэлэлцүүлэн акт үйлдэн, устгасан байна.

**Улсын бүртгэлийн архивын чиглэлээр хяналт шалгалт хийсэн тоон үзүүлэлтийг сүүлийн 3 жилээр харьцуулбал:**



**6. Захиргааны хэргийн шүүхэд маргаантай байгаа асуудлаар:**

Иргэн Л.Ганбатаас Хөвсгөл аймгийн улсын бүртгэлийн хэлтэст холбогдуулан “Хөвсгөл гурил тэжээл” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар томилсон 2009 оны төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолыг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай” нэхэмжлэлийн шаардлага гаргасныг Хөвсгөл аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх хүлээн авч, захиргааны хэрэг үүсгэн хэлэлцэх явцад “Улсын бүртгэгч Н.Азжаргалын “Хөвсгөл гурил тэжээл” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлтийг бүртгэсэн 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн бүртгэлийг хүчингүй болгох” гэж мөн “Өөрийн эзэмшиж буй Хөвсгөл гурил тэжээл” ХХК-ийн 15 хувийг 25 хувь болгон нэмэгдүүлэх” нэхэмжлэлийн шаардлагыг тус тус нэмэгдүүлсэнг захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралдаанаар нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон бөгөөд 2025 оны 05 дугаар сарын 13-нд ЗХДЗШШүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн шийдвэр гарсан. Мөн 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 001/ШТХ2025/0394 дугаар Монгол Улсын Дээд Шүүхийн Захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдааны тогтоолоор нэхэмжлэгч Л.Ганбатын итгэмжлэгдсэн төлөөлөгч Л.Сондомхишиг, өмгөөлөгч Г.Нацагдорж нарын хяналтын жуармаар гаргасан гомдлыг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх талаар дөрөв, түүнээс дээш шүүгч санал гаргаагүй, уг гомдол нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2-т заасан үндэслэлүүдэд хамаарахгүй байна.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 124 дүгээр зүйлийн 124.4-т заасныг удирлага болгон нэхэмжлэгч Л.Ганбатын итгэмжлэгдсэн төлөөлөгч Л.Сондомхишиг, өмгөөлөгч Г.Нацагдорж нарын хяналтын журмаар гаргасан гомдлыг Монгол Улсын Дээд Шүүхийн Захиргааны хэргийн шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзаж шийдвэрлэсэн.

Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын иргэн О.Цэрмаагийн “Охин Бат-Амгалангийн Тэмүүнзаяагийн овог эцгийн нэрийг өөрчилж Буддовчингийн Тэмүүнзаяа болгон

өөрчлөхийг Улсын бүртгэлийн хэлтэс даалгасан шийдвэр гаргуулах тухай” нэхэмжлэлтэй Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн шийдвэрээр нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

“Шидэт гал” ХХК-ийн өмчлөлийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн Ү-1723009130 дугаартай Хөвсгөл аймгийн Мөрөн сум 8-р баг, 49 тоот байрны 1, 3, 4, 5, 8, 11, 12, 13, 16, 21, 24, 25, 26, 27, 30, 31, 32, 34, 35 тоот орон сууцанд болон 30 авто зогсоолд тус тус урьдчилан тэмдэглэгээ хийсэн бүртгэлийг хүчингүй болгуулах” нэхэмжлэлтэй хэрэгт Хөвсгөл аймгийн ЗХАШШүүхээс нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, хэргийг хэрэгсэхгүй болгосон боловч ЗХДЗШШүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцаасан шийдвэр гаргасан. Мөн 2025 оны 08 дугаар сарын 04-ны өдрийн 126/ШШ2025/0015 дугаартай Хөвсгөл аймгийн ЗХАШШүүхээс “Шидэт гал” ХХК-ийн нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

2025 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 221/МА2025-0594 дугаартай Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалаар “Шидэт гал”-ын нэхэмжлэлтэй өмгөөлөгч О.Чулуунбаатарын давж заалдах гомдлыг хангахгүй орхисон.

Иргэн Д.Чанцалдуламын нэхэмжлэлтэй “Шидэт гал”, “Алаг Уул ган ББСБ” ХХК-ын хооронд байгуулсан 2021 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн №БГ07232021 дугаартай барьцааны гэрээг бүртгэсэн улсын бүртгэгчийн бүртгэлийг хүчингүй болгуулах тухай Захиргааны хэрэгт хариуцагчаар оролцож байгаа бөгөөд 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн шийдвэрээр нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн. Мөн 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 221/МА2025/0521 дугаартай Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалаар гуравдагч этгээдийн өмгөөлөгч О.Чулуунбаатарын давж заалдах гомдолд дурдсан шүүхэд хандан нэхэмжлэл гаргах болон урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн зэрэг үндэслэлээр анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл тогтоогдохгүй байх тул анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, гуравдагч этгээд нарын давж заалдах гомдлыг хангахгүй орхих нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн дүгнэв.

## **5. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Тус хэлтэс нь 2025 онд батлагдсан 2 055 106 700 төгрөгийн төсвөөс тайлант хугацаанд 1603029900 төгрөгийн санхүүжилт авч 1 590 477 590.92 төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, үндсэн үйл ажиллагааны орлогоос 219 899 298.00 төгрөгийг оруулж улсын төсөвт төвлөрүүлээд байна. Нийт зардлын 83 % буюу 1 325 757 341.60 төгрөгийг албан хаагчдын цалин нэмэгдэл хөлс, 11.1 % буюу 174 282 100.00 төгрөгийг ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлд, 5.9 % буюу 90 438 149.00 төгрөгийг урсгал зардалд зарцуулсан байна. Сар бүрийн орлогын мэдээг тасгуудаас авч нэгтгэн УБЕГазарт хүргүүлж байгаа бөгөөд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайланг УБЕГазраас ирүүлсэн чиглэлийн дагуу орлогын нэр төрөл, мөнгөн хөрөнгийн данс бүрээр, өглөг авлагын задаргаа бүрээр цаг хугацаанд чанартай гарган УБЕГазарт хүргүүлэн, Шилэн дансны сайт, Хөвсгөл

УБХэлтсийн мэдээллийн сайт, байгууллагын “Санхүүгийн ил тод байдлын” самбарт нээлттэйгээр байрлуулан ажиллаж байна. Мөн Шилэн дансны сайтад Гадаад паспортын шинэчлэгдсэн үйлчилгээний үнэ тариф, 2024 оны аудитын дүгнэлт, төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт хэмнэлтийн мэдээ тайланг цаг хугацаанд нь шивэн оруулж тайлант хугацаанд 171 мэдээлэл оруулахаас 146 мэдээллийг хугацаанд нь оруулж 2025 оны 11 дүгээр сарын шилэн дансны тайланг илгээв.

Улсын бүртгэгч нарын 2025 оны 1-11 дүгээр сарын үнэт цаасны кодтой тайланг хугацаа хоцроогүй нэгтгэн УБЕГазрын санхүүд хүргүүлээд байна.

Сангийн яамнаас хэрэгжүүлж буй онлайн программ болох цалин хөлсний PAYROLL программ, төрийн сангийн төлбөр тооцооны Finance программуудаар нягтлан бодох бүртгэлийн ажил гүйлгээгээ хийж гүйцэтгэж байна. Мөн ХЗДХЯамнаас хэрэгжүүлж буй e-accounting.mojha.gov.mn программын сургалтад хамрагдан 2025 оны үндсэн хөрөнгийн болон бараа материалын эхний үлдэгдэлийг оруулж төрийн сангийн гүйлгээ болон цалингийн нэгдсэн системээс таталт хийн 1 дүгээр сарын журналын бичилт хийж мөнгөн гүйлгээний тайлан гаргалаа.

Ажиллагсдын цалингийн тооцооллыг сард 2 удаа бодож, 2 программаар бодон тулган шалгаад, Нийгмийн даатгалын тайланг цалингийн программаас Нийгмийн даатгалын Portal систем руу excel файл руу хөрвүүлэн илгээж байгууллага хоорондын өр, авлаггүй ажиллалаа.

Хүний нөөцийн нэгдсэн системээс албан хаагчийн цалинтай холбоотой мэдээллийг сар бүр шинэчлэн татаж тулган баталгаажуулан цалинг тооцоолон татварын суутганы тайланг PAYROLL программаас татан оруулж тайлангаа цаг хугацаанд нь илгээлээ.

Тайлант хугацаанд УБЕГаас татан авах үнэт цаас, бараа материалыг машин техник хүн хүчний боломжоороо тасралтгүй ханган байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг тасалдуулалгүй ажиллаж байна.

Сумдын улсын бүртгэгч нарын үнэт цаасны тайланг код бүрээр тулган баталгаажуулж заасан хугацаанд нь УБЕГазрын санхүүд нэгтгэн хүргүүлсэн.

## **6. БАЙГУУЛЛАГЫН АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Хэлтсийн архив, бичиг хэргийн эрхлэгч, нярав нь баримт бичгийн бүрдэл, тэдгээрт тавих шаардлага MNS 5140-2:2021, Баримт бичгийн хэвлэмэл хуудас, тэдгээрт бүрдлийг байрлуулахад тавих шаардлага MNS 5140-3:2021 стандартуудыг мөрдөж албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа А4, А5 албан бичгийн кирилл, монгол бичгийн хэвлэмэл хуудас, тушаалын кирилл, монгол бичгийн хэвлэмэл хуудсыг стандартын дагуу ашиглаж байна.

Нийт бичиг хэргийн эргэлтийн тоо 36558. Тайлант хугацаанд Хэлтсийн даргын 30 тушаалыг бүртгэж ажилласнаас байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой А тушаал 4, хүний нөөцтэй холбоотой Б тушаал 26-г тус тус гарган хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан. Мөн тайлант хугацаанд улсын бүртгэлтэй холбоотой асуудлаар иргэдээс нийт 260 өргөдөл, гомдол ирсэн ба өргөдөл, гомдлыг холбогдох эрх бүхий албан тушаалтанд нь хуваарилан, 100% шийдвэрлэж ажилласан байна.

Бичиг хэргийн цахим программ болох ERP программаар албан бичгийг хүлээн авч хэлтсийн даргын тоон гарын үсгээр баталгаажуулан байгууллагуудад хүргүүлсэн. Мөн [Khuvsgul@burtgel.gov.mn](mailto:Khuvsgul@burtgel.gov.mn), [uburtgel@khs.gov.mn](mailto:uburtgel@khs.gov.mn), [21aimag@burtgel.gov.mn](mailto:21aimag@burtgel.gov.mn) төрийн цахим хаягаар бусад байгууллагаас ирүүлсэн албан бичгийг хүлээн авч, холбогдох албан хаагчид шилжүүлэн хариутай албан бичгийн хариуг хуулийн хугацаанд хүргүүлэн ажиллаж байна.


Хэлтсийн даргын 2025 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/04 дугаартай тушаалаар архивын улсын үзлэгт бэлтгэх ажлын хэсэг томлигдож улсын бүртгэлийн ерөнхий газар болон аймгийн архивын хэлтсээс ирүүлсэн аргачлал, шалгуур үзүүлэлтийн дагуу бэлтгэл ажлыг бүрэн хангаж ажилласан.

Энэ ажлын хүрээнд Хөвсгөл аймгийн архивын хэлтсийн 2025 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 14/1899 дугаартай “Улсын үзлэгийн бэлтгэл ажил хангах тухай” “Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалт”-ын аймгийн үзлэгээр тус хэлтэс 86.5 оноо авсан ба зөвлөмж чиглэлийн биелэлтийг ханган ажиллаж байна.

**Хэлтсийн албан бичгийн 2025 оны жилийн эцсийн эргэлтийг сүүлийн 3 жилээр харьцуулбал:**

Он	Ирсэн бичиг			Явсан бичиг	Хэлтсийн даргын тушаал			Өргөдөл гомдол
	Хариутай	Хариугүй	Нийт		А тушаал	Б тушаал	Нийт	
2023 он	879	671	1550	1341	2	21	23	122
2024 он	945	400	1355	1359	4	19	23	128
2025 он	1324	1318	2642	1642	4	26	30	260

**Албан бичгийн эргэлтийг сүүлийн 3 жилээр харьцуулбал:**



**Иргэдээс ирүүлсэн өргөдлийг төрлөөр нь авч үзвэл:**

- Иргэний бүртгэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар – 245
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар – 8
- Хуулийн этгээдийн бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой – 5
- Албан хаагчтай холбоотой гомдол – 2

**Иргэдээс ирүүлсэн өргөдлийн шийдвэрлэлтээр авч үзвэл:**

- Хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр Улсын бүртгэлийн ерөнхий газрын

Иргэний улсын бүртгэлийн газарт албан бичгээр хүргүүлсэн 28

- Албан бичгээр хариу хүргүүлсэн 36
- Утсаар холбогдон иргэнд холбогдох мэдээлэл заавар зөвлөмж өгсөн 14
- Харьяа сумын улсын бүртгэгчээр бүртгэл хийж шийдвэрлэгдсэн 13
- Иргэн өөрийн биеэр ирж хурууны хээ уншуулж, зөрчил арилгасан 2
- Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч

Б.Өлзийням нэгдсэн дүгнэлтийг үндэслэн мэдээллийн санд нэмэлт өөрчлөлт оруулж нөхөн шийдвэрлэсэн 190

Тус тус өргөдлийг ERP системд бүртгэн, хяналтын карт хөтлөн бүртгэлийн дэвтэр дээр бүртгэн даргын цохолтын дагуу албан хаагчдад өгч шийдвэрлүүлэн ажиллаж байна.

## **7. СУРГАЛТ, СЕМИНАР БОЛОВСОН ХҮЧНИЙГ БЭХЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР**

Хэлтэст зохион байгуулах 2025 оны сургалтын төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр 11 арга хэмжээтэй боловсруулж хэлтсийн даргаар батлуулан төлөвлөгөөний дагуу холбогдох сургалтанд хамрагдаж байгаа бөгөөд тайлант хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий газраас болон аймгийн ЗДТГ, бусад байгууллагаас зохион байгуулсан нийт 50 удаагийн сургалтад хэлтсийн бүх албан хаагчид болон хэлтсийн дарга, холбогдох албан хаагчид бүрэн хамрагдсан байна.

### **Улсын бүртгэлийн Ерөнхий газар болон аймгаас зохион байгуулсан сургалт:**

➤ 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан “Удирдах ажилтны цугларалт”-д хэлтсийн дарга Б.Мөнгөнзул оролцсон.

➤ 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулагдсан ЭБАТ-ын нэгдсэн сургалтад хэлтсийн дарга Б.Мөнгөнзул хамрагдсан.

➤ 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан “Улсын бүртгэгчийн мэргэшүүлэх сургалт”-д ЭХЭУБ-ийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Содномцэрэн хамрагдсан.

➤ 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр Хөвсгөл аймаг Төрийн аудитын газраас зохион байгуулсан сургалтад ерөнхий нягтлан бодогч Б.Мөнхдэлгэр оролцсон.

➤ 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Засгийн газрын хэрэг эрхлэх газраас зохион байгуулсан цахим сургалтад мэдээлэл технологийн ажилтан Э.Нарантуяа, бичиг хэргийн ажилтан, нярав Б.Маналжав нар хамрагдсан.

➤ 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулагдсан “Нийтийн мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллах сайтад мэдээлэл оруулах, үнэлгээ хийх сургалт”-д мэдээлэл технологийн ажилтан Э.Нарантуяа хамрагдсан.

➤ 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн Авлигатай тэмцэх газар болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн тасгийн хамтарсан сургалтад Иргэний улсын бүртгэлийн тасгийн албан хаагчид хамрагдсан.

➤ 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн Шилжилтийн програмын сургалтад ерөнхий нягтлан бодогч Б.Мөнхдэлгэр хамрагдсан.

➤ 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдөр УБЕГ-аас зохион байгуулсан “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарт зориулсан сургалт зохион байгуулах тухай удирдамж”-ийн дагуу эд хөрөнгийн эрхийн бүртгэгч нар цахимаар сургалтанд хамрагдсан.

➤ 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн Төрийн албаны зөвлөлийн сургалтад хэлтсийн дарга Б.Мөнгөнзул, мэдээлэл технологийн ажилтан Э.Нарантуяа нар оролцсон.

➤ 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулагдсан Shilen.gov.mn системийн сургалтад мэдээлэл технологийн ажилтан Э.Нарантуяа хамрагдсан.

➤ 2025 оны 03 дугаар сарын 10-13-ны өдрүүдэд Хэл яриа сонсголын бэрхшээлтэй иргэдэд “Шидэт гар-2” ахисан шатны сургалтыг аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв Дохионы хэлний багш, орчуулагч, Докторант Б. Саранчимэгтэй хамтран зохион байгуулсан. Уг сургалтад хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасгийн иргэний улсын бүртгэгч М.Ням-Оджаргал, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Б.Цэнд-Аюуш нар нийт 9 цагийн сургалтад хамрагдаж, сертификаттай болсон. Ахисан түвшний сертификат авсан 2 албан хаагч хэлтсийн албан хаагчдад дохионы хэлний ахисан шатны сургалтыг үе шаттай зохион байгуулж байна.

➤ 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулагдсан “Дэлхийн мөнгөний долоо хоног” аяны хүрээнд хүүхэд залуусыг багаас нь эхлэн санхүүгийн мэдлэгтэй болгох, санхүүгийн зөв шийдвэр гаргахад шаардагдах чадвар, хандлага эзэмшүүлэх сургалтад ерөнхий нягтлан бодогч Б.Мөнхдэлгэр, Иргэний улсын бүртгэгч Б.Мөнхзул нар хамрагдлаа.

➤ 2025 оны 03 дугаар сарын 25-26-ны өдөр зохион байгуулагдсан “Хүүхэд хамгаалын хамтарсан багийн чадавхжуулах” сургалтад Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч П.Даваадулам оролцсон.

➤ Гэр бүл хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас 2025 оныг “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвөөс зохион байгуулсан сургалт иргэний улсын бүртгэгч С.Дэлгэрмөрөн, гэрээт Б.Дуламсүрэн нар хамрагдсан.

➤ 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Хөвсгөл аймгийн засаг даргын тамгын газар, Онцгой байдлын газартай хамтарсан “ГАЗАР ХӨДЛӨЛТ, ГАЛ ТҮЙМЭР ЦАГ АГААРЫН АЮУЛТ ҮЗЭГДЛИЙН ”-давагдашгүй хүчин зүйлийн талаарх сургалтад Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Б.Өлзийням хамрагдсан.

➤ 2025 оны 03 дугаар сарын 31, 04 дүгээр сарын 01-ний өдрүүдэд Улсын бүртгэлийн байгууллагын удирдах ажилтны сургалт, зөвлөгөөн амжилттай зохион байгуулагдаж хэлтсийн дарга Б.Мөнгөнзул, Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ө.Батнасан нар оролцлоо.

➤ ”Цахим нотариатын системд зуучлалын модуль нэвтрүүлэх” ажлыг улс даяар хэрэгжүүлж эхэлсэнтэй холбоотой Улсын бүртгэлийн ерөнхий газар, нотариатын танхим хамтарсан сургалтад 2025 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нар хамрагдсан.

➤ 2025 оны 04 дүгээр сарын 13-нд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /шинэчилсэн найруулгын төсөлд/ оруулсан өөрчлөлтийн талаархи мэдээллийг хэлтсийн дарга Б.Мөнгөнзул эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэл хийж байгаа 10 суманд цахимаар холбогдон уншиж танилцуулж хуулийн төсөлд тусгах саналыг нэгтгэн 5 сарын 13-ны өдөр ХЭУБГ-т хүргүүлсэн.

➤ 2025 оны 04 дүгээр сарын 17-18-ны өдөр зохион байгуулагдсан “Мэдээлэл технологийн албан хаагч нарт мэдлэг олгох” сургалтад хэлтсийн мэдээлэл технологийн ажилтан Э.Нарантуяа оролцсон.

➤ 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдөр Хөвсгөл аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв, Нэгдсэн эмнэлгийн нүдний эмчтэй хамтран хараа шалгах эрт илрүүлгийн үзлэг хийх, урьдчилан сэргийлэх мэдлэг олгох, олдмол хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Харааны эрүүл мэнд” сургалтад Иргэний улсын бүртгэгч С.Дэлгэрмөрөн, архивч Д.Пүрэвсүрэн нар хамрагдан оролцлоо.

➤ 2025 оны 05 дугаар сарын 12-13-ны өдөр зохион байгуулагдсан “Аймаг, дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын (ахлах) бүртгэгч нарт зориулсан мэргэжил арга зүйгээр дэмжих” сургалтад Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Б.Өлзийням, иргэний улсын бүртгэгч Б.Мөнхзул нар хамрагдсан.

➤ 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулагдсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хөгжил, хиймэл оюун ухаан ба цахимжилт” уриан дор зохион байгуулагдсан “Ажил олгогчдын нэгдсэн зөвлөгөөн”-д хэлтсийн дарга Б.Мөнгөнзул, архивч Б.Оюунцэрэн нар хамрагдсан.

➤ 2025 оны 06 дугаар 09-ний өдөр Нийтийн ил тод байдлын /Shilen.gov.mn, Gov.mn/ системүүдийг хариуцан ажилладаг төрийн байгууллагын албан хаагчдын чадавхыг сайжруулах зорилгоор Төрийн цахим үйчилгээний зохицуулалтын газраас зохион байгуулсан сургалтад мэдээлэл технологийн ажилтан Э.Нарантуяа оролцсон.

➤ 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр Жендэрийн үндэсний хороо болон Засгийн газрын хэрэг эрхлэх газраас зохион байгуулсан “Жендэр ба бодлого төлөвлөлт” сургалтад хэлтсийн дарга Б.Мөнгөнзул хамрагдсан.

➤ 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулагдсан “Хамгийн сайн халамж – хөдөлмөр эрхлэлт” сургалтад иргэний улсын бүртгэгч С.Дэлгэрмөрөн, үйлчлэгч Б.Дуламсүрэн, гэрээт Р.Төмөрбаатар, Ө.Батдалай нар хамрагдлаа.

➤ 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр Хөвсгөл аймгийн Тагнуулын хэлтсийн дарга “Төрийн болон албаны нууц хамгаалалт” сэдвээр хэлтсийн болон сумдын зарим нэг албан хаагчид хамрагдсан байна.

➤ 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Улсын бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний түүхт 85 жилийн ой арга хэмээний хүрээнд “Ур чадвар, ажил мэргэжлийн” тэмцээн зохион байгуулж 4 баг оролцон өрсөлдсөнөөс Баянзүрх сумын улсын бүртгэгч Н.Азжаргал ахлагчтай “Дөрвөн бэрх” баг тэргүүн байр эзэлж, шилдэг илтгэгчээр Рэнчинлхүмбэ сумын бүртгэгч П.Оргилсайхан шалгарч тэмцээн амжилттай зохион байгуулагдсан.

➤ 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Худалдан авах ажиллагааны газраас “Худалдан авах үйл ажиллагаа”-г сурталчлах сарын аяны хүрээнд төсвийг ерөнхийлөн захирагч буюу захиалагч байгууллагуудад сургалт хэлэлцүүлэг,

авилга, ашиг сонирголоос ангид байх сургалтад Ахлах нягтлан бодогч Б.Мөнхдэлгэр хамрагдлаа.

➤ 2025 оны 10 дугаар сарын 21-23 өдрүүдэд терроризмтой тэмцэх зөвлөлийн Хөвсгөл аймаг дахь салбар зөвлөлийн гишүүн байгууллагын удирдлага болон алба хаагчдад Хөвсгөл аймгийн мөрөн нисэх буудлаас зохион байгуулж буй “Хаан шонхор-2025” дадлага сургалтанд хэлтсийн дарга Б.Мөнгөнзул, Б.Өлзийням, Б.Маналжав нар оролцсон.

➤ 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Санхүү, төрийн сангийн хэлтсийн Төрийн сангийн удирдлагын системийн хөгжүүлэлт сургалтад хэлтсийн ахлах нягтлан бодогч Б.Мөнхдэлгэр хамрагдсан байна.

➤ 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Хэлтсийн 2025 оны сургалтын төлөвлөгөөний дагуу “Хүний хөгжил, ёс суртахууны төлөвшил” сэдвээр Монголын Үндсэний Техникийн Их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал Ц.Өлзийтогтох сургалт хийж хэлтсийн 16 албан хаагч хамрагдлаа.

➤ 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдөр Санхүү төрийн сангийн хэлтсийн Төрийн сангийн удирдлагын системийн хөгжүүлэлт сургалтад ахлах нягтлан бодогч Б.Мөнхдэлгэр хамрагдсан байна.

➤ 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдөр Хөдөлмөрийн харилцаа хөдөлмөрийн аюулгүй байдлын хорооны мэргэжилтэн А.Баярмаа “Байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй” сэдвээр сургалт хийлээ.

➤ 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдөр Хөвсгөл аймгийн Ёс зүйн хорооны дарга Р.Машбат “Төрийн албан хаагчийн ёс зүйн” сэдэвт сургалтад хамрагдлаа.

➤ 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдөр “Ажлын орчин дахь харилцааны эерэг болон сөрөг нөлөө үр дагавар” сэдвээр Насан туршын боловсролын төвийн сургалтын менежер Д.Энхбат сургалт хийв.

➤ 2025 оны 11 дугаар сарын 5-6-ний өдөр Улсын бүртгэлийн байгууллагын санхүүгийн албан хаагчдын нэгдсэн сургалтанд ахлах нягтлан бодогч Б.Мөнхдэлгэр хамрагдлаа.

➤ 2025 оны 11 дугаар сарын 7-ны өдөр “Сэтгэлзүй ба байгууллагын уур амьсгал” сэдвээр Хүүхэд Гэр бүл Хөгжил хамгааллын газрын сэтгэл зүйч, судлаач Д.Буянбат сургалт орлоо.

➤ 2025 оны 11 дугаар сарын 10-ны өдөр “Авилгын гэмт хэрэг” сэдвээр улсын бүртгэгч Б.Болормаа хэлтсийн албан хаагчид танхимын сургалт зохион байгуулалаа.

➤ 2025 оны 11 дугаар сарын 11-ний өдөр “Хөвсгөл аймгийн Засаг даргын” 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн А/606 дагуу ХГБХХГ-аас “Гэр бүлийн боловсролын сургалт” сургалтын танхимд хийж хэлтсийн албан хаагчид хамрагдсан.

➤ 2025.10.16-ны Төрийн албаны зөвлөлөөс “7:4:10” “Төрийн албан хаагчдад Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Батцэцэг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч хэлтсийн бүх албан хаагчид хамрагдсан.

➤ 2025.10.23-ны Төрийн албаны зөвлөлөөс “7:4:10” Хүний эрхийн боловсролын талаарх сургалтад хэлтсийн бүх албан хаагчид хамрагдсан.

➤ 2025.10.30-ны Төрийн албаны зөвлөлөөс “7:4:10” Монгол бичгийг дижитал орчинд эзэмших нь сэдвээр “Болорсофт, Чимэгэ, Эгүнэ, системийг үүсгэн

байгуулагч гүйцэтгэх захирал С.Бадрал Ч.Мөнхнаран нар мэдээлэл өгч хэлтсийн бүх албан хаагчид хамрагдсан.

➤ 2025.11.06 нд Төрийн албаны зөвлөлөөс “7:4:10” Тагнуулын ерөнхий газрын Төрийн нууцын ахлах хошууч П.Амарбаясгалан “Төрийн нууцын хадгалалт, хамгаалалт” сэдвээр Цахим, (вибинар) Zoom –ээр сургалт зохион байгуулагдлаа.

## **8. ХЭЛТСЭЭС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БУСАД АЖЛУУД**

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Д.Пүрэвдоржид хэлтсийн албан хэрэгцээнд шаардлагатай туулах чадвар сайтай авто машин шийдвэрлүүлэх тухай хүсэлтийг уламжлан уаз фургон машин шийдвэрлүүлсэн. Тухайн авто машиныг хэлтсийн үндсэн хөрөнгөнд авах тухай зөвшөөрлийн хүсэлтийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлэн ажилласан боловч урсгал засварын зардал төсөвт тусгагдаагүйн улмаас тухайн автомашиныг засварлах боломжгүй болж орон нутгийн өмчийн газар буцаан шилжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын албанаас зохион байгуулсан “ҮҮРГЭЭ УХАМСАРЛАЯ” аянд нэгдэж иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр цуврал 8 контентыг бүтээн иргэдэд соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулсан.

Улсын бүртгэлийн хэлтэс нь Хуульчийн про боно /Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа үзүүлэх өдөр/ арга хэмжээг Аймгийн засаг даргын тамгын газар, Хууль эрх зүйн хэлтсээс ирүүлсэн чиглэлийн дагуу 2025 оны 05 сарын 1-ны өдөр “Гараас гарт” иргэдэд бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх, зөвлөгөө мэдээлэл өгөх нээлттэй өдөрлөг хэлбэрээр амжилттай зохион байгууллаа. Тус хэлтсээр үйлчлүүлсэн бүх иргэнд халуун цай кофе, жимсний шүүсээр үйлчилж иргэн, эд хөрөнгийн эрхийн бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэлийн гарын авлага материалуудыг тарааж зөвлөгөө мэдээллээр хангаж ажилласан.

Тус арга хэмжээний хүрээнд: Иргэний бүртгэлийн чиглэлээр 105 иргэнд зөвлөгөө мэдээлэл бүртгэлийн үйлчилгээ үзүүлж төрсний гэрчилгээ-8, гэрлэлт-3, нас баралт-5, төрсний гэрчилгээ дахин олголт -5, иргэний үнэмлэх-10, шилжилт хөдөлгөөн-6, лавлагаа-31, тоон гарын үсэг-36 иргэнд олгосон байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр: Анхны бүртгэл-2, өмчлөх эрх шилжүүлэх-10, барьцааны гэрээ бүртгэл-26 хийж 50 гаруй иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч гэрчилгээг богино хугацаанд буюу ажлын 8 цагт гаргаж иргэдэд олгосон.

Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр: Шинээр хуулийн этгээд бүртгүүлэх-5, мэдээлэлд орсон өөрчлөлтийн бүртгэл-4, лавлагаа-3, гэрчилгээ олголт-10 иргэнд олгож бүртгэлийг өдөрт нь бүртгэлжүүлсэн.

“Эрдмийн далай” ЕБС-ийн Ө.Баярмаа багштай 11-р ангийн Б бүлгийн 32 сурагчийг байгууллагын үйл ажиллагаатай танилцуулж, 2 хүүхэд иргэний цахим үнэмлэх, 1 хүүхэд үндсэний энгийн гадаад паспорт захиалж Хэлтсийн дарга

өрөөндөө хүлээн авч байгууллагын онцлог, давуу тал болон хуульч, эрх зүйч мэргэжлийн талаар товч мэдээлэл хүргэн ажилласан.

Монгол улсын Төрийн албаны зөвлөлийн 30 жилийн ойг угтан Хөвсгөл аймгийн төрийн албан салбар зөвлөлөөс зохион байгуулж буй “Шинэтгэлээр түүчээлсэн төрийн алба” аянд хэлтсийн албан хаагчид нэгдэж аяны хүрээнд батлагдсан 9 арга хэмжээ бүхий төлөвлөгөөний хэрэгжилтийг 100 хувь ханган ажилласан.

Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас 2025 оныг “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэмд эерэгээр сурталчлан таниулж, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн технологийн шийдлүүдийг танилцуулах зорилготой “Ability Expo” –арга хэмжээнд төрийн болон хувийн байгууллагаас үйлчилгээ авах нөхцөл, үйлчилгээний ажилтаны ур чадвар, хандлага ойлголтыг нэмэгдүүлэх, төрийн байгууллагын тэгш хүртээмжтэй үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах хэрэглэгчийг сэтгэл ханамжтай үйлчилгээгээр угтах, үдэх хэрэглэгчидэд үйлчлэх үйлчилгээний стандартыг мөрдөн ажиллалаа.

## **85 ЖИЛИЙН ОЙН АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД**

Улсын бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний 85 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд 15 арга хэмжээтэйгээр 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдөр хэлтсийн даргаар батлуулан, хэрэгжүүлэх хугацааны дагуу дараах арга хэмжээг зохион байгуулан ажилласан байна.

### Ойг угтсан бүтээлч ажлын хүрээнд:

➤ Батнасангийн Бүжин охины элэг шилжүүлэн суулгах мэс засал хийлгэхэд зориулсан “Эх үрсийн элбэрэл” тоглолтын хандивт 420000 төгрөг хандивласан.

Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Холбооны гишүүн Соёлын тэргүүний ажилтан С.Чинбат нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах Олон Улсын өдрийг тохиолдуулан “Сэтгэлийн гэгээ”-тоглолтыг зохион байгуулахад 2025 оны 01-р сарын 29-ний өдөр байгууллагын нийт ажилтан албан хаагчид 420000 /мянган төгрөг/ -ний дэмжлэг үзүүлсэн.

Монгол улсад хүүхдийн хөдөлгөөн байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан хүүхэд өсвөр үеийнхний сайн сайхны төлөө зүрх сэтгэлээ зориулан ажиллаж байгаа хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын хамт олонд 1 000 000 төгрөг, 257 000 төгрөгний үнэ бүхий ус шүүгч хандивласан.

➤ 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр Хөвсгөл аймгийн Мөрөн сумаас хойш 5 км-т байрлах Соёмбо цогцолборт “УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТӨГӨЛ” байгуулж тохижууллаа.

Төгөлд: Хайлаас 50 ширхэг, голт бор 25 ширхэг, монос 10 ширхэг нийт 85 мод тарьсан. Төгөлийг арчилж ургуулах ажлыг тасралтгүй зохион байгуулж хэлтсийн нийт албан хаагчдыг хамруулан “Төгөл услах хуваарь” гарган ажилласан.

➤ Зөөврийн 4G төхөөрөмж ашиглан улсын бүртгэлийн явуулын үйлчилгээг зохион байгуулж Мөрөн сумын “Нутгийн аваргууд” ерөнхий боловсролын сургууль, ШУТИС-н харьяа Хөвсгөл аймаг дахь Политехник коллежийн багш, ажилтан албан хаагч, сурагч нарт цахим гадаад паспортын бүртгэл, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлийн үйлчилгээг үзүүлэн ажиллалаа. Мөн Тариалан, Рашаант, Рэнчинлхүмбэ, Цагааннуур, Бүрэнтогтох, Цэцэрлэг, Галт, Их-Уул, Эрдэнэбулган, Цагаан-Уул, Цагаан-Үүр, Баянзүрх сумдын улсын бүртгэгч нар зөөврийн 4G төхөөрөмж ашиглан улсын бүртгэлийн явуулын үйлчилгээг зохион байгуулж хөгжлийн бэрхшээлтэй, зорилтот бүлгийн 121 иргэнд улсын бүртгэлийн бүх төрлийн үйлчилгээг үзүүлсэн. Мөн Улсын бүртгэлтийн ерөнхий газрын даргын 2025 оны 10 сарын сарын 10-ны өдрийн 1/284-р удирдамжийн дагуу хэлтсийн даргын удирдамж гарган батлуулж Цагааннуур, Улаан-уул, Түнэл, Арбулаг, Бүрэнтогтох, Тосонцэнгэл сумдад “Нээлттэй хаалганы өдөрлөг” зохион байгуулж 595 иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээ, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

➤ “Улсын бүртгэлийн өдөр” нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулж Мөрөн, Улаан-Уул, Эрдэнэбулган сумын 118 иргэнд иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийг үйлчилгээг үзүүлж, зөвлөгөө мэдээллийг өгч ажилласан. Мөн Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын 10 сарын 07-ны өдрийг 1/285 тоот явуулан үйлчилгээ зохион байгуулах удирдамжийн дагуу 10 дугаар сарын 14-30 хооронд Улаан-уул, Цагааннуур, Арбулаг, Түнэл, Бүрэнтогтох, Тосонцэнгэл сумдад нээлттэй өдөрлөг зохион байгуулж иргэний 181, эд хөрөнгө, хуулийн этгээдийн 64, 350 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

Албан хаагч ажилтнуудыг шагнал, урамшуулалт нэр дэвшүүлэх зорилтын хүрээнд:

Албан хаагч, ажилтнуудыг шагнал, урамшуулалд нэр дэвшүүлэх ажлыг зохион байгуулж Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025.05.07-ны өдрийн 2/6317 албан бичгийн дагуу Төрийн дээд, Засгийн газрын болон төрийн албаны, салбар, байгууллагын шагналд шагнуулахаар нэр дэвших шаардлага хангасан 7 албан хаагчийн материалыг холбогдох журмын дагуу бүрдүүлж хүргүүлж иргэний улсын бүртгэгч Б.Батжаргал “Хууль зүйн яамны жуух бичиг”, Рэнчинлхүмбэ сумын улсын бүртгэгч П.Оргилсайхан, Төмөрбулаг сумын улсын бүртгэгч Д.Пүрэвдорж “Улсын бүртгэлийн ерөнхий Тэргүүний ажилтан”, Шинэ-Идэр сумын улсын бүртгэгч Н.Болормаа, Мөрөн сумын улсын бүртгэгч С.Дэлгэрмөрөн нар Улсын бүртгэлийн Ерөнхий газрын “Жуух бичиг”-ээр тус тус шагнагдсан.

Ойн баярын хурал спорт, урлагын наадам зохион байгуулах ажлын хүрээнд:

➤ Улсын бүртгэлийн байгууллагын ажилтан, албан хаагчдын бие бялдрыг хөгжүүлэх зорилго бүхий “Спорт-2025” нэгдсэн сургалт 2025.05.22-23-ны өдөр дартс, ширээний теннис, сагсан бөмбөг, волейбол гэсэн 4 төрлөөр зохион байгуулагдсан. Уг нэгдсэн сургалтад Хангайн бүсийн багт тус хэлтсийн архив, бичиг хэргийн ажилтан Б.Маналжав, Баянзүрх сумын улсын бүртгэгч Н.Азжаргал, Чандмань-Өндөр сумын улсын бүртгэгч Т.Доньдмаа, Иргэний улсын бүртгэгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Ням-Оджаргал нар хэлтсийн даргын удирдлаган дор оролцож эрэгтэй сагсан бөмбөгийн төрөлд “Гутгаар байр” эзэлсэн амжилтыг үзүүлсэн.

#### Бүртгэлийн байгууллагын түүхт 85 жил арга хэмжээний бүтээл гаргах ажлын хүрээнд:

Төрсний гэрчилгээ, гэрлэсний гэрчилгээ, анхны бүртгэлийн дэвтэр, иргэний үнэмлэх, гадаад паспорт, үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ, хуулийн этгээдийн гэрчилгээ зэрэг эх нотлох баримтаар “Он цагийн хэлхээ”, байгууллагын үе үеийн албан хаагчдын түүхэн фото зургаар “Гэгээн үйлсийн эзэд” үзэсгэлэнг хэлтсийн байрны хоёр давхарын коридорыг тохижуулан байршууллаа.

#### Мэдээллийн хэрэгслээр сурталчлах, таницуулга мэндчилгээ хийх ажлын хүрээнд:

Улсын бүртгэлтийн ерөнхий газрын даргын 2025 оны 10 сарын сарын 10-ны өдрийн 1/284-р удирдамжийн хүрээнд “Мэргэжлээрээ бахархая” цахим контентийн уралдаанд Ханх сумын улсын бүртгэгч Б.Содномцэрэн, хэлтсийн улсын бүртгэгч, архивч нар хамтран “Миний бахархал-миний мэргэжил” сэдвээр, Иргэний бүртгэлийн тасаг “Үйлчилгээний соёл, үнэт зүйлс” сэдвээр контент бүтээж улсын бүртгэлийн ерөнхий газрын пэйж хуудсанд байршуулсан. Одоогийн байдлаар “Үйлчилгээний соёл, үнэт зүйлс” контент 1 700 лайк, 69 комент, 275 шэйртэй байна.

#### Бусад ажлын хүрээнд:

➤ “Эко явган аялал”-ыг 2025 оны 06 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулж, хэлтсийн нийт албан хаагчдын дунд явган алхалт, ойрын зайн гүйлт, буухиа тэмцээнүүдийг зохион байгуулж амралтын өдрийг спортлог өнгөрүүллээ. Мөн 10 дугаар сарын 25-ны бямба гарагт “Үүргэвчтэй аялал” зохион байгуулан албан хаагчид Соёмбо цогцолборлуу 6 км-ын зайд алхаж амралтын өдрийн эрүүл мэнддээ анхаарч үр дүнтэй өнгөрүүллээ.

➤ Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн “Мэргэжлээрээ бахархъя” цахим контентын уралдаанд “Миний бахархал-миний мэргэжил” сэдвийн хүрээнд хоёр, “Үйлчилгээний соёл-үнэт зүйлс” сэдвийн хүрээнд нэг нийт гурван контент бүтээж хүргүүлсэн.

➤ Улсын бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний түүхт 85 жилийн ой арга хэмээний хүрээнд хэлтсийн албан хаагчдын дунд “Ур чадвар, ажил мэргэжлийн тэмцээн 2025” зохион байгуулж 4 баг оролцон өрсөлдсөнөөс Баянзүрх сумын улсын бүртгэгч Н.Азжаргал ахлагчтай “Дөрвөн бэрх” баг тэргүүн байр эзэлж, шилдэг

илтгэгчээр Рэнчинлхүмбэ сумын бүртгэгч П.Оргилсайхан шалгарч өргөмжлөл үнэ бүхий зүйлээр шагнагдлаа.

➤ Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2025 оны 10 дугаар сарын 08-нд батлуулсан удирдамжийн дагуу “Улсын бүртгэл-хүүхдийн нүдээр” гар зургийн уралдаан хэлтсийн албан хаагчдын хүүхдүүдийн дунд зарлаж 13 бүтээл ирүүлснээс шилдэгүүдээ шалгаруулан шагнаж урамшууллаа.

## 9.ДҮГНЭЛТ

Тус хэлтэс нь өдөр тутмын үйл ажиллагаандаа Улсын бүртгэлийн ерөнхий хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, хөдөлмөрийн дотоод журам, үйлчилгээний стандартыг мөрдөн ажиллаж, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэн ажиллалаа.

2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 32 арга хэмжээнээс 30 арга хэмжээний биелэлтийг ханган ажиллаж байна.

Зорилт 1.3, 1.6-ийн хүрээнд төвлөгдсөн арга хэмжээ нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын хэмжээнд хэрэгжиж эхлээгүй байна. Цаашид хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдах арга хэмжээг төлөвлөхдөө чиглэлийн газраас зөвлөмж, чиглэл авч биелэгдэхүйцээр төлөвлөхөд анхааран ажиллах болно.

Иргэний улсын бүртгэлийг өмнөх оны тайлант хугацаатай харьцуулахад 22,2% буурсан, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл 10.8% буурсан, хуулийн этгээдийн эрхийн улсын бүртгэл 24%-аар өссөн тус тус үзүүлэлттэй байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг Баянзүрх, Галт, Их-Уул, Тариалан, Хатгал, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр, Шинэ-Идэр, Рашаант, Цэцэрлэг, Эрдэнэбулган зэрэг 11 сумдын улсын бүртгэгч нарт хуулийн этгээдийн улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх эрх олгосон. Ингэснээр сумдад эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл 693, хуулийн этгээдийн улсын бүртгэл 237 хөтлөгдсөн байна. Сумдад эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл болон хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх болсонтой холбоотойгоор иргэдийн эд хөрөнгөө бүртгүүлж эдийн засгийн эргэлтэд оруулах таатай нөхцөл бүрдсэн ч нотариатын үүрэг гүйцэтгэгч, газрын даамал, иргэдийн хурал /газрын хаягжилтын тогтоол/, банк зэрэг байгууллагын албан хаагчдыг ажлын хариуцлагын сайжруулах, чадавхжуулах тал дээр байгууллагын дээд шатны удирдлагатай хамтран ажиллах шаардлагатай байна.

Тус аймаг нь 23 сум 1 тосгонтой бөгөөд хилийн боомт 1, хил орчмын 10 сум байдаг бөгөөд үндэсний энгийн гадаад паспортын бүртгэл сумдад хөтлөгддөг болсноор хил зорчих үнэмлэх олголт буюу цагаан хуудас буурсан үзүүлттэй байна. Хилийн сум болон хил орчмын сумдад жилдээ 1-2 удаагийн “Нээлттэй хаалганы өдөр” зохион байгуулж, сумдад үндэсний энгийн гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх боломжтой болсон нь иргэдийн хувьд илүү хялбар, түргэн шуурхай болсон ч нөгөө талаас сумдад гадаад паспортыг хүргүүлэх шуудангийн

зардал нэмэгдэж байна. Иймд тус хэлтсийн шуудан холбооны зардал хүрэлцэхгүй байгаа тул нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих, алслагдсан багийн иргэдэд хүрч үйлчлэх ажил зохион байгуулахад шаардлагатай албан хаагчдын томилолт, байгууллагын тээвэр шатахууны зардлыг үйл ажиллагааны батлагдсан төсөвт тогтмол хүрэлцэхүйц тусгадаг байх. Мөн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулын зардал хүрэлцдэггүй, хөдөлмөрийн дотоод журмын дагуу төсөвд тусгадаг байх.

Улсын бүртгэлийн байгууллагын нууцын баталгаа гаргадаг албан хаагчдын мэргэжлийн нэр хүнд, хариуцлагын тогтолцоо, хөхиүлэн дэмжих, хүндэтгэх, хамгаалах, ажил үүргээ явуулах нөхцлөөр хангах, эрүүл мэнд, сэтгэл санааны аюулгүй байдлыг зохицуулах зорилгоор эрх зүйн байдлыг хуульчилж өгөх шаардлагатай байна.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:  
ЗАХИРГААНЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.БОЛОРМАА

ХЯНАСАН:  
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.МӨНГӨНЗУЛ